Монос Хүнс ХК

Санхүүгийн тайлан болон
Хараат бус аудиторын тайлан
2025 оны 12 сарын 31

МОНОС ХҮНС ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

АГУУЛГА

	ХУУДАС
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	1
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	2
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	3
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	4
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	5

МОНОС ХҮНС

2026.03.03 № _____

танай _____ -ны № _____ -т

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Хүрэлбаатар овогтой Ананд би Монос Хүнс ХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын хувьд, Агваандорж овогтой Отгондарь би тус Компанийн Гүйцэтгэх захирлын хувьд, Цэгмэд овогтой Дэлгэрмаа би тус Компанийн Санхүү хариуцсан захирлын хувьд ард хавсаргасан 1-ээс 45 хуудас дахь Компанийн 2025 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2025 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, шударгаар илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Х.Ананд	А.Отгондарь	Ц.Дэлгэрмаа
ТУЗ-ын дарга	Гүйцэтгэх захирал	Санхүү хариуцсан захирал

+976 77773525
foods@monos.mn
www.monosfoods.mn
Монгол улс, Улаанбаатар хот, Сонсголонгийн зам гудамж, 32/3 тоот, Үйлдвэрийн баруун бүс, БГД, 20-р хороо

Онч Аудит ХХК
15-р давхар Ай Си Си
цамхаг, Жамъян гүний
гудамж Сүхбаатар дүүрэг,
1-р хороо Улаанбаатар хот
14240, Монгол Улс

Утас: +976 70100450
976 70120450
Факс: +976 70130450
www.onch.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Монос Хүнс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд,

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Монос Хүнс ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бид, дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт- Нягтлан бодох бүртгэлийн стандартууд (цаашид "СТОУС-Нягтлан бодох бүртгэлийн стандартууд" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой, нөлөө бүхий асуудал юм. Бид санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд энэхүү асуудлыг бүхэлд нь анхаарч авч үзсэн бөгөөд дүгнэлт гаргахдаа уг асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй болно. Бид дараах асуудлыг Аудитын гол асуудал гэж тодорхойлсон.

Аудитын гол асуудал	Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд
Орлого хүлээн зөвшөөрөлт Аудитын Олон Улсын Стандартаар борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой залилангийн эрсдэл аливаа байгууллагад зайлшгүй байдаг гэж үздэг. Борлуулалтын орлого нь удирдлагын гүйцэтгэлийг үнэлэх гол үзүүлэлтүүдийн нэг тул борлуулалт бодитоор үүссэн эсэх болон борлуулалтын орлогыг зөв тайлант үед хүлээн зөвшөөрч бүртгэсэн эсэх эрсдэлийг аудитын гол асуудал болгон авч үзсэн.	Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд: • Бид удирдлагын зүгээс борлуулалтын орлого нь бодитоор үүссэн болон зөв тайлант хугацаанд бүртгэгдсэн эсэхийг хянаж буй хяналтуудын талаар ойлголт олж авч тэдгээрийн загварчлалыг үнэлж, хэрэгжилтийг шалгасан. • Компаний орлого хүлээн зөвшөөрөх нягтлан бодох бүртгэлийн бодлого нь СТОУС 15 - *Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого* -той нийцэж буй эсэхийг үнэлсэн.

Onch & Company тухай

Onch & Company нь Монгол Улсын Оюуны өмчийн газарт бүртгэлтэй барааны тэмдэг юм. Энэхүү тэмдэгийг Онч Аудит ХХК, Онч Зөвлөх үйлчилгээ ХХК, Онч Татварын Зөвлөх үйлчилгээ ТМЗ ХХК-ууд ашиглах эрхтэй бөгөөд тэдгээр нь аудит, эрсдэлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээг Монголын харилцагчдад үзүүлдэг байгууллагууд юм.

Тус баримт бичигт ерөнхий мэдээлэл агуулагдсан бөгөөд энэхүү танилцуулгаар Onch & Company, түүний гишүүн компани, холбоотой талуудыг мэргэжлийн зөвлөгөө өгсөнд эсвэл үйлчилгээ үзүүлсэнд тооцохгүй. Та өөрийн санхүү, бизнест нөлөөлөхүйц ямарваа шийдвэр гаргах эсвэл үйлдэл хийхээс өмнө мэргэжлийн зөвлөхөд хандан зөвлөгөө авна уу. Энэхүү танилцуулгад найдаж шийдвэр гаргасан эсвэл үйлдэл хийсний улмаас ямарваа хохирол учирсан бол бид ямарваа хариуцлага хүлээхгүй болно.

© 2025. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Onch & Company-тай холбогдоно уу.

Аудитын гол асуудал (үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд
	• Компаний томоохон харилцагчидтай жилийн туршид хийгдсэн борлуулалтын орлогыг тулган баталгаажуулсанаас гадна борлуулалтын тоо хэмжээ болон үнийн мэдээлэлд үндэслэн нийт борлуулалтын орлогын хүлээгдэж буй хэмжээг тооцоолж санхүүгийн тайланд бүртгэгдсэн борлуулалтын орлоготой харьцуулж шалгасан. • Борлуулалтын орлогыг гүйцэтгэлийн үүрэг хангагдсан үед хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах үүднээс жилийн туршид хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнээс түүвэр сонгон авч борлуулсан бараа материалын хүргэлтийг худалдан авагч тал хүлээн зөвшөөрсөн эсэхийг нотлох холбогдох баримт бичгүүдтэй тулгаж шалгасан.

Бусад мэдээлэл

Компанийн удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд жилийн тайлан багтах бөгөөд санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт багтахгүй.

Энэхүү санхүүгийн тайланд өгсөн манай аудиторын дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн баталгаажуулах дүгнэлт өгдөггүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын ажлын хүрээнд олж мэдсэн мэдээллээс материаллагаар зөрүүтэй эсвэл зөрүүтэй мэт харагдаж байгаа эсэхийг авч үзэх ёстой. Хэрэв бид хийсэн ажил дээрээ үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг алдаатай байна гэж үзвэл бодит мэдээллийг тайлагнах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн тайлагнах зүйл байгаагүй болно.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС- Нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Удирдлага санхүүгийн тайланг бэлтгэх үедээ Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, уг чадамжид нөлөөлөхүйц нөхцөл байдлын талаар шаардлагатай үед тодруулах болон Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг гарган гэрээт ажлын гэрээнд заасан эрх бүхий этгээд болох та бүхэнд хүргүүлэх нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал бол материаллаг гэж үздэг.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг баримталсан болно. Мөн түүнчлэн:

- Залилан болон алдаанаас үүсэж болохуйц санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай болон зохистой аудитын баримт, нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг. Учир нь залилан нь үгсэн тохирох, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, худал батламж гаргах болон дотоод хяналтыг зөрчих зэрэг явдлуудаас үүссэн байх магадлалтай байдаг.

- Бид Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус зөвхөн нөхцөл байдалд тохирох аудитын горимуудыг сонгох зорилгоор дотоод хяналтуудыг судалдаг.

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцөлийг үргэлжлүүлэн хангах Компанийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг аудиторын дүгнэлтэд тусгаж анхааруулах, мөн тэдгээр тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай байдаг. Бид дүгнэлтээ аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотлох баримтад үндэслэн гаргадаг. Тиймээс ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд саад учруулж болох юм.

- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бүхэлд нь үнэлдэг ба ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар толилуулсан эсэхийг үнэлдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудын талаар мэдээлдэг ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын томоохон алдаа болон дутагдал орно.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглах эрх бүхий этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа, бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын гол асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээлэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.

Онч Аудит ХХК

Онч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
2026 оны 3-р сарын 3

Б. Уранбилэг
Партнер, МНБ

Ерөнхий мэдээлэл
2025 оны 12-р сарын 31-ээр тасалбар болгосон тайлант жил

Компанийн нэр	**Монос Хүнс ХК**
Улсын бүртгэлийн дугаар	9010002005
Үндсэн үйл ажиллагаа	Компанийн үндсэн үйл ажиллагаа нь шүүс, ус, ундаа, чихэр, үрэл, цай, зөөлөн капсултай бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон гадаад худалдаа болно.

Хувьцаа эзэмшигчид:	**Хувьцааны тоо**	**Эзэмшлийн хувь**
Л.Хүрэлбаатар	286,198,433	70.00%
Ц.Цэцэнзориг	14,284,706	3.49%
Ц.Ганзориг	14,120,665	3.45%
Х. Ананд	10,929,975	2.67%
А. Түмэнжаргал	5,996,176	1.47%
Л. Эрдэнэчимэг	4,630,628	1.14%
Б. Пунсалмаа	3,093,249	0.76%
Бусад	69,596,596	17.02%
	408,850,428	**100%**

Гүйцэтгэх Удирдлага	Гүйцэтгэх захирал	А.Отгондарь
	Санхүү хариуцсан захирал	Ц.Дэлгэрмаа
	Борлуулалт, маркетинг хариуцсан захирал	Э.Амарболд
	Үйлдвэрлэл хариуцсан захирал	Б.Баянжаргал

Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ-ийн дарга	Х.Ананд
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Г.Золжаргал
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Н.Улаанхүү
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	М.Сарандаваа
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Д.Гэрэлт-Од
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Д.Энхжаргал
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Б.Бат-Уул
	ТУЗ-ийн хараат гишүүн	Л.Хүрэлбаатар
	ТУЗ-ийн хараат гишүүн	А.Отгондарь
	ТУЗ-ийн хараат гишүүн	Х.Солонго
	ТУЗ-ийн хараат гишүүн	Ц.Цэцэгбадам
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Н.Цагаанхүү

Байнгын хаяг	**Монос Хүнс ХК** Үйлдвэр, Сонсголонгийн зам гудамж, 32/3 тоот, Үйлдвэрийн баруун бүс, БГД, 20-р хороо, Улаанбаатар хот, Монгол улс
Аудитор	**Онч Аудит ХХК** 15-р давхар, Ай Си Си цамхаг, Жамъян гүний гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот, Монгол улс

МОНОС ХҮНС ХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2025	2024
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	53,185	2,292,388
Дансны ба бусад авлага	6	7,433,664	5,497,442
Урьдчилгаа	7	962,238	544,383
Бараа материал	8	8,040,808	7,806,736
Бусад эргэлтийн хөрөнгө	9	-	1,428,799
		16,489,895	**17,569,748**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	10	38,036,346	35,455,386
Ашиглах эрхтэй хөрөнгө	11	3,757,625	2,589,657
Биет бус хөрөнгө	12	298,099	327,070
Урьдчилгаа	7	2,293,251	2,951,402
Хойшлогдсон татварын хөрөнгө	17	62,855	95,157
		44,448,176	**41,418,672**
Нийт хөрөнгө		**60,938,071**	**58,988,420**
Өр төлбөр ба эздийн өмч			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны ба бусад өглөг	13	4,914,965	3,949,391
Гэрээний өр төлбөр	14	130,716	93,651
Богино хугацаат зээл	15	5,966,648	12,979,016
Хойшлогдсон засгийн газрын буцалтгүй тусламж	15	1,200,788	1,678,419
Түрээсийн өр төлбөр	11	1,624	116,255
Орлогын албан татварын өглөг	17	73,599	337,059
Нөөц	8	270,203	239,115
		12,558,543	**19,392,906**
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	15	17,333,220	13,507,432
Хойшлогдсон засгийн газрын буцалтгүй тусламж	15	1,266,780	2,467,568
Түрээсийн өр төлбөр	11	102,495	66,972
		18,702,495	**16,041,972**
Нийт өр төлбөр		**31,261,038**	**35,434,878**
Эздийн өмч			
Хувьцаат капитал	16	2,318,182	2,318,182
Нэмж төлөгдсөн капитал	16	6,835,733	6,835,733
Хуримтлагдсан ашиг		20,523,118	14,399,627
		29,677,033	**23,553,542**
Нийт өр төлбөр ба эздийн өмч		**60,938,071**	**58,988,420**

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНОС ХҮНС ХК
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2025	2024
Борлуулалтын орлого	18	47,803,112	37,993,254
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	19	(22,535,148)	(19,715,030)
Нийт ашиг		**25,267,964**	**18,278,224**
Бусад үйл ажиллагааны орлого		450,935	66,054
Ерөнхий ба удирдлагын зардал	20	(5,498,570)	(4,331,963)
Борлуулалт ба маркетингийн зардал	21	(11,509,325)	(8,303,161)
Бусад зардал	23	(340,657)	(206,206)
Үйл ажиллагааны ашиг		**8,370,347**	**5,502,948**
Санхүүгийн орлого	24	48,611	177,218
Санхүүгийн зардал	24	(2,312,277)	(1,107,243)
Дансны авлагын үнэ цэнийн бууралтын алдагдал		(104,429)	-
Бусад олз ба гарз	25	2,614,409	(10,409)
Татварын өмнөх ашиг		**8,616,661**	**4,562,514**
Орлогын албан татварын зардал	17	(857,769)	(511,814)
Тайлант жилийн цэвэр ашиг		**7,758,892**	**4,050,700**
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)	16.4	18.98	9.91

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНОС ХҮНС ХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагд-сан ашиг	Нийт
2024 оны 1 сарын 1-ний дүн	**2,318,182**	**6,835,733**	**10,348,927**	**19,502,842**
Тайлант жилийн ашиг	-	-	4,050,700	4,050,700
2024 оны 12 сарын 31-ний дүн	**2,318,182**	**6,835,733**	**14,399,627**	**23,553,542**
Тайлант жилийн ашиг	-	-	7,758,892	7,758,892
Олгосон ногдол ашиг (Тодруулга 16.3)	-	-	(1,635,401)	(1,635,401)
2025 оны 12 сарын 31-ний дүн	**2,318,182**	**6,835,733**	**20,523,118**	**29,677,033**

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНОС ХҮНС ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2025	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн цэвэр ашиг		**7,758,892**	**4,050,700**
Тохируулга:			
Орлогын албан татварын зардал	17	857,769	511,814
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	10	2,289,540	1,281,952
Биет бус хөрөнгийн хорогдлын зардал	12	74,829	108,548
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал	11	386,449	131,017
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус гарз/(олз)		23,578	(5,034)
Найдваргүй авлагын зардал		104,429	-
Бараа материал данснаас хассаны гарз	23	217,293	199,684
Бараа материалын (буцаалт)/хорогдол		(26,957)	26,957
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	10,25	52	633
Бусад эргэлтийн хөрөнгө борлуулсаны олз	25	(2,611,015)	-
Түрээсийн нөхцөл өөрчилсний олз	11	-	(16,259)
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	11	(3,446)	(922)
Хүүгийн орлого	24	(23,289)	(150,462)
Зээлийн хүүгийн зардал	16	2,077,189	988,874
Түрээсийн хүүгийн зардал	11	27,327	32,868
		11,152,640	**7,160,370**
Бараа материалын өсөлт		(424,408)	(3,088,455)
Дансны ба бусад авлагын өсөлт		(2,040,652)	(1,362,396)
Урьдчилгаа төлбөрийн (өсөлт)/бууралт		(757,204)	137,441
Дансны ба бусад өглөгийн өсөлт		480,261	34,366
Гэрээний өр төлбөрийн өсөлт		37,065	45,152
		8,447,702	2,926,478
Төлсөн орлогын албан татвар	17	(1,088,927)	(395,850)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**7,358,775**	**2,530,628**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн		(4,639,851)	(2,085,421)
Ашиглах эрхтэй хөрөнгө худалдан авахад төлсөн		(402,633)	(2,719,140)
Бусад эргэлтийн хөрөнгө борлуулсанаас орсон мөнгөн орлого		4,450,000	-
Биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн	12	(45,858)	(21,573)
Хүлээж авсан хүү	24	23,289	150,462
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(615,053)**	**(4,675,672)**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Авсан зээл	15	24,476,000	18,377,364
Төлсөн зээл	15	(29,371,081)	(38,437,284)
Төлсөн зээлийн хүү	15	(2,195,171)	(2,906,826)
Төлсөн ногдол ашиг	16	(1,635,401)	-
Төлсөн түрээсийн өр төлбөр	11	(257,272)	(133,527)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(8,982,925)**	**(23,100,273)**
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл		-	226
Мөнгөн хөрөнгийн бууралт		**(2,239,203)**	**(25,245,091)**
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	5	**2,292,388**	**27,537,479**
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5	**53,185**	**2,292,388**

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНОС ХҮНС ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Монос хүнс ХК (цаашид "Компани" гэх) нь анх 2012 оны 3-р сарын 1-нд үүсгэн байгуулагчдын 1 дүгээр тогтоолоор Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. Компанийг улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, 2012 оны 3-р сарын 12-нд 9010002005 дугаар бүхий Улсын бүртгэлийн гэрчилгээ, 5568927 дугаартай бүртгэлийг тус тус авсан. 2018 оны 10-р сарын 19-нд хувьцаа эзэмшигчид компанийг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлсэн.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь шүүс, ус, ундаа, чихэр, үрэл, цай, зөөлөн капсул зэрэг бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа юм.

2025 оны 12-р сарын 31-ний байдлаарх үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээний дагуу хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувьцаат капитал нь дараах байдалтай байна. Үүнд:

		2025 оны 12 сарын 31	
Хувьцаа эзэмшигчдийн нэр	**Эзэмшлийн хувь**	**Хувьцааны тоо**	**Нийт (мян.төг)**
Л.Хүрэлбаатар	70.00%	286,198,433	1,622,745
Ц.Цэцэнзориг	3.49%	14,284,706	80,994
Ц.Ганзориг	3.45%	14,120,665	80,064
Х. Ананд	2.67%	10,929,975	61,974
А. Түмэнжаргал	1.47%	5,996,176	33,998
Л. Эрдэнэчимэг	1.14%	4,630,628	26,256
Б. Пунсалмаа	0.76%	3,093,249	17,539
Бусад	17.02%	69,596,596	394,612
Нийт	**100%**	**408,850,428**	**2,318,182**

2025 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн ажилчдын тоо 270 (2024 онд: 268) байсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөл санхүүгийн тайланг 2026 оны 3 сарын 3-ны өдөр батлан гаргасан.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй

2.1 Мөрдсөн стандарт

Компани нь санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-с батлан гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт - Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

2.2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Компанийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм. Эдгээр санхүүгийн тайлангуудыг төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт болон тайлбарууд (хамтад нь 'СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд' гэх)-ын дагуу бэлтгэсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг түүхэн өртөгт суурилан бэлтгэсэн.

Санхүүгийн тайлангуудыг Компанийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд үндэслэн бэлтгэсэн.

Санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар Тодруулга 3-т тодруулсан.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.3 Орлого хүлээн зөвшөөрөлт

2.3.1 Гүйцэтгэлийн үүрэг болон орлого хүлээн зөвшөөрөлтийн хугацаа

Компанийн орлогын дийлэнх хэсэг нь худалдан авагчид барааны хяналт шилжсэн үед буюу тодорхой нэг хугацаанд орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн барааны борлуулалтаас үүсдэг. Энэ нь ерөнхийдөө харилцагчид барааг хүргэсэн үе гэж ойлгоно. Хэдий тийм боловч экспортын борлуулалтын хувьд хяналт нь явах боомт, эсвэл ирэх боомтод хүргэгдсэн үед буюу худалдан авагчтай байгуулсан гэрээний тусгайлсан нөхцөлөөс хамаарч шилжиж болно.

Хяналт шилжих цэгийг тодорхойлоход шаардлагатай зарим шийдэл: бүтээгдэхүүнийг тохиролцсон байршилд биетээр хүргэж өгөх, Компани барааг цаашид биет байдлаар эзэмшихээ болих, ихэвчлэн төлбөр авах эрхтэй байх (хүргэлтэд нэг удаагийн төлбөр) болон бараатай холбоотой мэдэгдэхүйц эрсдэл болон урамшуулал Компанид үлдээгүй байх зэрэг болно.

Жижиг цөөн тооны гэрээнүүд нь нэхэмжлэх болон эзэмших нөхцөлөөр хийгддэг. Компани биет байдлаар эзэмшиж байгаа хэдий ч зөвхөн дараах тохиолдлуудад ийм төрлийн гэрээний орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг:

- Гэрээний нөхцөл нь бодитой, үндэслэлтэй (худалдан авагч хүссэн);
- Бэлэн бүтээгдэхүүн нь харилцагчид хамааралтайгаар тусдаа тодорхойлогдсон;
- Бүтээгдэхүүнийг харилцагчид биетээр шилжүүлэхэд бэлэн байх; болон
- Компани нь өөр худалдан авагчид өгөхөөр бүтээгдэхүүнийг шууд ашиглах эрхгүй байх.

2.3.2 Бараа материалын буцаалт ба буцаалтын нөөц

Буцаалтаар хүлээн авах бараа материал нь харилцагч нараас буцаагдана гэсэн хүлээлттэй байгаа барааг буцаан авах компанийн эрхийг илэрхийлнэ. Энэхүү хөрөнгө нь өмнөх бараа материалын дүнгээс буцаагдсан бүтээгдэхүүний үнэ цэний бууралтыг оролцуулсан буцаан авах өртгийг хассан дүнгээр хэмжигдэнэ. Компани нь харилцагчдаас ирж магадгүй буцаалт болон буцаагдан ирж буй бүтээгдэхүүний нэмэлт үнэ цэний бууралтын тооцооллын хэмжээг тогтмол шинэчилж байдаг.

Компанийн борлуулж буй зарим барааны чанарын буцаалт үүсэж болох бөгөөд уг буцаалтыг НББОУС 37, Нөөц, болзошгүй өр төлбөр ба хөрөнгө-д заасны дагуу баталгааны үүргээ биелүүлэхтэй холбоотой зардлыг нөөцөөр бүртгэнэ. Буцаалтын нөөц нь үйлчлүүлэгчээс хүлээн авсан зарим эсвэл бүх төлбөрийг буцаан олгох үүргийг илэрхийлж байгаа бөгөөд Компанийн харилцагчид барааны борлуулалтын буцаалт өгөхөөр хүлээгдэж буй дүнгээр хэмжигдэнэ. Компани нь буцаалтын нөөцийн тооцооллоо тайлант жил бүрийн эцэст шинэчилдэг.

2.3.3 Ажил гүйлгээний үнийг тодорхойлох

Компанийн ихэнх орлого нь тогтмол үнэтэй гэрээний орлогоос үүсдэг бөгөөд гэрээ тус бүрээс олсон орлогын дүнг тэдгээр тогтмол үнэтэй хамааралтайгаар тодорхойлдог. Онцлог зүйлсийг доор тайлбарлав:

- Зарим гэрээ нь худалдан авагчид буцаах эрхийг олгодог. Эдгээр нь ихэвчлэн эцсийн хэрэглэгчид шууд хүргэх борлуулалттай хамааралтай байдаг, гэхдээ зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Түүхэн туршлага нь Компанийг буцаагдах барааны дүнг найдвартай тооцоолох боломжийг олгодог. Мөн бараа буцаалтаар ирэх үед өмнө нь хүлээн зөвшөөрч бүртгэсэн байсан орлогод буцаалт хийгдэхгүй байх өндөр магадлалтай байхаар орлогын дүнг хязгаарладаг; болон
- Биет хэмжээний хөнгөлөлттэй холбоотой хувьсах төлбөрийг тодорхойлсон үед гэрээний орлогыг тооцоолохдоо хүлээн зөвшөөрсөн орлогын дүнд ирээдүйд буцаалт хийхгүй гэсэн өндөр магадлалтай үед л биет хэмжээний хөнгөлөлттэй холбоотой хувьсах төлбөрийг хязгаарлана.

2.3.4 Гүйцэтгэлийн үүргүүдэд ажил гүйлгээний үнийг хуваарилах

Ихэнх гэрээний хувьд зарж буй бүтээгдэхүүн нэг бүр нь тогтмол нэгжийн үнэтэй байдаг. Тиймээс ийм төрлийн гэрээний (нийт гэрээний үнэ нь захиалсан нэгжийн тоонд хуваагдана) хувьд захиалсан нэгж бүрд гэрээний үнийг хуваарилахад ямар нэгэн шийдэл ашиглах шаардлагагүй. Худалдан авагч нь нэгээс олон төрлийн бүтээгдэхүүн захиалбал Компани нь гэрээний нийт үнийг бүтээгдэхүүний төрөл тус бүрийн дангаар нь борлуулах үнэтэй (бүх бүтээгдэхүүний төрлийг тусад нь тодорхойлох боломжтой бөгөөд тусад нь борлуулдаг) уялдуулан хуваарилж тодорхойлно.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.3 Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

2.3.4 Гүйцэтгэлийн үүргүүдэд ажил гүйлгээний үнийг хуваарилах (үргэлжлэл)

Зарим гол худалдан авагчтай бизнесээ үргэлжлүүлэн хадгалахын тулд компани нь тэдгээртэй ирээдүйд дахин захиалга өгсөн тохиолдолд хөнгөлөлт үзүүлэх гэрээг байгуулж болно. Ийм хөнгөлөлт нь 'материаллаг эрх' гэсэн ойлголтыг бүрдүүлж өгдөг ба үүний үр дүнд анхны борлуулалтаас хүлээн авсан төлбөрийн зарим хэсгийг хойшлуулах ба дараа үеийн борлуулалт хийгдсэн үед эсвэл хөнгөлөлтийн хугацаа дууссан үед орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Удирдлагууд нь дараах хоёр шалтгааны улмаас ирээдүйн хөнгөлөлтийн эрхэд хуваарилагдах гэрээний орлогын дүнг тооцоолохдоо өмнөх туршлагад үндэслэсэн суурийг авч үзээгүй. Нэгдүгээрт, өмнөх туршлагаас авч ашиглах ийм төрлийн их хэмжээний гэрээ байгаагүй. Мөн хоёрдугаарт, худалдан авагч бүр нь нэмэлт захиалгаар хийгдэх борлуулалтын дүн болон магадлалд хоёуланд нь нөлөө үзүүлэх өөр өөрийн онцлог нөхцөлтэй байсан. Тиймээс тооцооллыг анхны гэрээ хийгдсэн үед холбогдох худалдан авагчтай тухайн хөнгөлөлтийг ямар хэмжээгээр хэрэгжүүлэх тухай хэлэлцэн ярилцсаны үндсэн дээр хийсэн.

2.4 Гэрээний өр төлбөр

Худалдан авагчаас төлбөрийг хүлээн авсан бараа, үйлчилгээг тухайн худалдан авагчид нийлүүлэх аж ахуйн нэгжийн үүрэг бөгөөд компани нь тухайн худалдан авагчид барааг нийлүүлснээр орлогыг хүлээн зөвшөөрдөг. Ихэнх тохиолдолд төлбөр хүлээн авсан хугацаанаас хойш нэг жилийн дотор бүтээгдэхүүнийг худалдан авагчид нийлүүлдэг.

2.4.1 Практик чөлөөлөлт

Компани нь дараах практик чөлөөлөлтийн давуу талыг ашигласан:

- Бараа эсвэл үйлчилгээний хяналтыг харилцагчид шилжүүлэх болон төлбөрийг хүлээн авах хугацааны хооронд нэг жил эсвэл түүнээс бага хугацаа байвал санхүүжилттэй холбоотой бүрэлдэхүүн хэсгийг бүртгэхгүй; мөн
- Гэрээг олж авахтай холбоотой өсөн нэмэгдэх зардлын хугацаа нь нэг жил болон түүнээс бага байвал зардлаар бүртгэх.

2.5 Гадаад валют

Компанийн үйл ажиллагаа эрхэлдэг үндсэн эдийн засгийн орчны валютаас ("бүртгэлийн валют") бусад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлсэн.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг бүртгэлийн тайлангийн өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Мөнгөн хөрөнгөөр төлөгдөх хөрөнгө, өр төлбөрийг дахин хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдалд шууд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

Тайлант жилийн явцад хэрэглэж байсан ханш дараах байдалтай байна:

	Дундаж ханш		Хаалтын ханш	
Валют	**2025**	**2024**	**2025 оны 12 сарын 31**	**2024 оны 12 сарын 31**
Ам.доллар	3,545.29	3,390.04	3,556.66	3420.25
Юань	493.26	471.09	508.78	468.57
Вон	2.50	2.49	2.46	2.32

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.6 Санхүүгийн хөрөнгө

2.6.1 Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх

Эдгээр хөрөнгө нь харилцагчид хүргэх бараа болон үйлчилгээний нөөцөөс (худалдааны авлага гэх мэт) ихэвчлэн үүсдэг. Гэхдээ мөн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд гэрээний мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрддэг бусад төрлийн санхүүгийн хөрөнгөөс үүсдэг. Эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр тэдгээрийг олж авах эсвэл гаргахтай холбоотой шууд хамааралтай гарсан ажил гүйлгээний зардлыг нэмж бүртгэх ба дараа үед үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон үнэ цэний бууралтыг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Богино болон урт хугацаат худалдааны авлагын үнэ цэний бууралтын хасагдуулгыг СТОУС 9-д заасан хялбаршуулсан арга-д үндэслэн нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлох замаар хасагдуулгын матриц ашиглан байгуулдаг. Ингэхдээ худалдааны авлагын төлөгдөхгүй байх магадлалыг үнэлдэг. Худалдааны авлагын нийт хугацааны туршид авлага төлөгдөхгүй байхаас үүсэх хүлээгдэж буй алдагдлыг тодорхойлж уг хүлээгдэж буй алдагдлыг энэхүү магадлалаар үржүүлж тооцно. Худалдааны авлагын хувьд уг хасагдуулгыг тусдаа нөөцийн дансанд бүртгэх ба цэвэр дүнгээр тайлагнана. Харин хүлээн зөвшөөрсөн алдагдлыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Худалдааны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Бусад авлага, холбоотой талуудаас авах авлага болон холбоотой талуудад олгосон зээлд байгуулсан үнэ цэний бууралтын хасагдуулгыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар урьдчилан таамагласны үндсэн дээр тооцоолно. Хасагдуулгын дүнг тодорхойлохдоо ашигласан аргачлал нь санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан эсэхэд үндэслэнэ. Санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гараагүй бол 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан бол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үнэ цэний бууралт үүссэн гэж тогтоогдвол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүүгийн орлоготой нь хамт цэвэр сууриар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Компанийн хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайлан дахь дансны болон бусад авлага болон мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь бэлэн мөнгө, банкин дахь харилцах, хадгаламж, 3 сар болон түүнээс богино хугацаатай түргэн хөрвөх бусад хөрөнгө оруулалт болон мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор банкны овердрафт багтана. Банкны овердрафтыг санхүүгийн байдлын тайлангийн богино хугацаат өр төлбөрийн хэсэгт зээл болон өр төлбөрөөр тусгадаг.

2.7 Санхүүгийн өр төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- Банкны зээл болон Компанийн бүцаан дуудах давуу эрхтэй хувьцааг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмждэг. Ингэснээр санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн зардлыг эргэн төлөлтийн хугацааны турш тогтмол хувиар тооцоолох боломжийг олгодог. Санхүүгийн өр төлбөр бүрийн зорилгын хувьд хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купоны өглөг багтдаг; мөн
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн худалдааны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

2.8 Хувьцаат капитал

Компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүд санхүүгийн өр төлбөр, хөрөнгийн шалгуурыг хангахгүй байх тохиолдолд л тэднийг өмчөөр ангилна. Компани энгийн хувьцаагаа өмчийн хэрэглүүр гэж ангилсан.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.9 Нэмж төлөгдсөн капитал

Хувьцаа гаргалтаас хүлээн авсан төлбөр болон нэрлэсэн үнийн зөрүүг нэмэгдэж төлөгдсөн капиталаар өмчийн хэрэглүүрээр бүртгэдэг. Хувьцаа гаргалттай шууд холбоотой гарсан зардлыг нэмэгдэж төлөгдсөн капиталыг бууруулж бүртгэдэг.

2.10 Ногдол ашиг

Ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчдэд Компани дэх хувь эзэмшлийн хувьд үндэслэн олгогдох өгөөжийн татан авалт юм. Ногдол ашиг олгох эсэх болон нэгж хувьцаанд хэдэн төгрөгийн ногдол ашиг олгохыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр тогтоох бөгөөд түүний зарласан тайлант хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

2.11 Түрээс

2.11.1 Түрээсийг тодорхойлох

Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг компани түрээс гэж үздэг. Түрээс гэдэг нь дараах шалгууруудыг хангасан гэрээ юм:

- Тодорхойлсон хөрөнгөтэй;
- Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртдэг; мөн
- Компани хөрөнгийг ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Бэлтгэн нийлүүлэгч тухайн түрээсийн хөрөнгийг солих, орлуулах эрхтэй эсэхийг Компани харгалзан үзэх ба хэрэв тийм бол тухайн гэрээг түрээсийн гэрээ гэж үзэхгүй.

Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо Компани нь хууль ёсны эзэмшил эсвэл бусад боломжит үр өгөөжтэй хамааралтай бус харин зөвхөн хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөжийг л авч үзнэ.

Компани нь хөрөнгийн ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо ашиглалтын хугацааны туршид хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахаа удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг харгалзан үзнэ. Хөрөнгийн шинж чанарын улмаас шийдвэр нь урьдчилан тодорхойлогдсон тул тухайн хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахтай холбоотой хамгийн их хамааралтай шийдвэр гаргахгүй байх үед Компани нь хөрөнгийн загварыг гаргах үед ашиглалтын хугацааны турш хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахыг урьдчилан тодорхойлох байдлаар оролцсон эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь эдгээр шалгуурыг хангахгүй бол Компани СТОУС 16-аас бусад холбогдох СТОУС-ын мөрдөнө.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.12 Биет бус хөрөнгө

2.12.1 Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгө

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэний бууралтыг хассан дүнгээр бүртгэж эдийн засгийн ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулна.

Бизнесийн нэгдлийн үед биет бус хөрөнгийг худалдан авсан аж ахуйн нэгжээс нь салгаж болохуйц эсвэл бусад гэрээгээр хүлээсэн эрхийг үүсгэж байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Ийм төрлийн биет бус хөрөнгийн үнийн дүнг тохирох үнэлгээний арга техникийг ашиглан тооцоолно.

Компанийн хүлээн зөвшөөрсөн нөлөө бүхий биет бус хөрөнгө, тэдгээрийн эдийн засгийн ашиглалтын хугацааг доор харууллаа:

Биет бус хөрөнгө	Ашиглалтын хугацаа
Программ хангамж	4-5 жил
Патент	14-18 жил
Барааны тэмдэг	4-8 жил
Бусад биет бус хөрөнгө	3 жил

2.12.2 Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө (хөгжүүлэлтийн зардал)

Дараах шалгууруудыг хангасан бол дотооддоо хөгжүүлсэн бүтээгдэхүүний зардлыг капиталжуулна:

- Борлуулах бүтээгдэхүүнийг боловсруулах техникийн боломжтой;
- Хөгжүүлэлтийг гүйцэтгэх хэмжээний зохих нөөц бололцоотой;
- Бүтээгдэхүүнийг гүйцэт боловсруулж, борлуулах зорилготой;
- Компани бүтээгдэхүүнээ борлуулах чадвартай;
- Бүтээгдэхүүний борлуулалт нь ирээдүйн эдийн засгийн өгөөж бий болгох; ба
- Төслийн зарцуулалтыг найдвартай хэмжих боломжтой.

Боловсруулсан бүтээгдэхүүнийг борлуулснаар олохоор таамаглаж буй өгөөжийн хугацаанд капиталжуулсан хөгжүүлэлтийн зардлыг хорогдуулна. Хорогдуулалтын зардлыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн борлуулалтын өртөгт болон удирдлагын зардалд тусгана.

Хөгжүүлэлтийн зардал болон дотоодын төслийн судалгааны үе шатанд гарсан зардал нь дээрх шалгууруудыг хангахгүй байх тохиолдолд ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

2.13 Үндсэн хөрөнгө

2.13.1 Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, гаалийн татвар болон бүхаан нөхөгдөхгүй бусад худалдааны татвар болон тухайн хөрөнгийг Компанийн зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах худалдан авалттай холбоотой зардлууд багтах бөгөөд үүнд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг.

Үндсэн хөрөнгийн өртөгт мэргэжлийн ур чадварын хөлс, шаардлага хангасан хөрөнгийн хувьд Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу капиталжуулсан зээлийн зардлыг (Тодруулга 2.18) багтаасан болно. Эдгээр шинж чанаруудыг ашиглалтад оруулахад бэлэн болсны дараа үндсэн хөрөнгийн зохих ангилалд ангилдаг.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.13 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

2.13.2 Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт

Үндсэн хөрөнгө нь өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүнг хассан өртгөөр тайлагнагдана.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар Компанид эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дүнгээр хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг.

Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд Компани үндсэн хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогоо НББОУС 16 Үндсэн Хөрөнгө болон НББОУС 8 Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа-ны дагуу дахин үнэлгээний загвараас өртгийн загварт шилжүүлэн өөрчилсөн.

Үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт, захиргааны эсвэл хараахан тодорхойлогдоогүй зориулалтаар баригдаж буй үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дүнг хассан өртгөөр тайлагнана. Өртөг нь мэргэжлийн үйлчилгээний хөлс ба шалгуур хангасан хөрөнгийн хувьд Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу капиталжуулсан зээлийн өртөг багтаана. Эдгээр хөрөнгийн элэгдлийн тооцоо нь бусад эд хөрөнгийн адил тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад бэлэн болсон үед эхэлдэг.

2.13.3 Элэгдэл

Дуусаагүй барилгыг бүрэн барьж, ашиглахад бэлэн болох хүртэл элэгдүүлдэггүй. Үндсэн хөрөнгийн бусад бүх зүйлсэд элэгдэл тооцох бөгөөд ингэснээрээ тэдний дансны үнэ цэнийг таамагласан ашиглалтын хугацааны туршид данснаас хасах юм. Тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлэх өртгөөс шулуун шугамын аргаар элэгдэл тооцох бөгөөд элэгдлийг тайлант жилийн зардал, бараа материалын өртгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Элэгдүүлэх өртөг нь тухайн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны эцэст буцаан борлуулах боломжит үлдэх өртгийг хассан дүн байна. Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлант жилийн эцэс бүрд дахин хянаж үзнэ.

Үндсэн хөрөнгийн ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

Үндсэн хөрөнгө	Ашиглалтын хугацаа
Газрын сайжруулалт	10 жил
Барилга	5-40 жил
Машин, тоног төхөөрөмж	3-11 жил
Тээврийн хэрэгсэл	5-10 жил
Тавилга, эд хогшил	3-10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	2-7 жил
Бусад	5-11 жил

2.14 Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө

Компани хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглахаас илүү борлуулснаар үлдэгдэл өртгийг нөхнө гэж үзсэн үед хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөөр ангилдаг. Энэ нөхцөлийг хангахын тулд хөрөнгө болон худалдах багц нь зах зээл дээр тохиромжтой үнээр идэвхтэй арилжаалагддаг, өөрийн одоо байгаа нөхцөл байдлаараа түргэн борлогдох боломжтой, удирдлага худалдан борлуулахаар төлөвлөж байгаа, нэг жилийн дотор борлуулах магадлал өндөртэй байх ёстой.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг дансны үнэ болон борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар хэмждэг. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд элэгдэл тооцохгүй.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.15 Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө зэрэг бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэ нь эргэн нөхөгдөхгүй байж болохыг илэрхийлсэн үйл явдал буюу өөрчлөлт тухайн нөхцөлд байгаа эсэхийг шалгаж үзэх ёстой. Хөрөнгийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээс (ашиглалтын үнэ ба бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээс их) давсан үед хөрөнгийг бууруулах бичилт хийдэг.

Тухайлсан хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох боломжгүй байх тохиолдолд хөрөнгүүдийг бие даан тодорхой мөнгөн урсгал бий болгохгүй хөрөнгийн бүлгийн хамгийн бага нэгж болгох хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн хувьд үнэ цэнийн бууралтыг шалгана.

Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэний бууралтын алдагдал нь мөнгө бий болгогч нэгжүүдэд хуваарилагдсан гүүдвиллийн дүнг эхлээд бууруулна. Үнэ цэний бууралтын алдагдлын үлдэгдэл хэсэг нь бусад хөрөнгийн хамрах мөнгө бий болгогч нэгжүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна. Дараа үеүдэд гүүдвилийг оролцуулахгүйгээр бүх хөрөнгийн хувьд өмнө нь бүртгэгдсэн үнэ цэний бууралтын гарз нь нөхөгдсөн буюу үнэ цэнийн бууралт үгүй болсон эсэхийг дахин шалгана. Хэрвээ мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн нь үүний дансны үнээс давсан бол үнэ цэнийн бууралт нөхөгдсөн гэж үзнэ.

Үнэ цэний бууралтын гарзыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

2.16 Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд өртөг ба цэвэр боломжит үнэ цэний аль багаар нь хэмжинэ. Бараа материалын өртөгт худалдан авалттай холбоотой бүх зардал, хувиргалтын зардал болон бараа материалыг өнөөгийн байршил ба нөхцөлд авч ирэхтэй холбоотой гарсан бусад бүх зардал багтана.

Цэвэр боломжит үнэ цэнэ нь тогтоогдсон борлуулах үнээс зарж борлуулахтай холбоотой зардлуудыг хассан дүнгээр тодорхойлогдоно. Хуучирсан, илүүдэл нөөцтэй, болон удаан гүйлгээтэй бараа материалуудыг олж тогтоож, цэвэр боломжит үнэ хүртэл нь бууруулж бүртгэдэг.

2.17 Санхүүгийн орлого ба зардал

Санхүүгийн орлого, зардалд хүүгийн орлого ба зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз/гарз, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэний олз/гарз, ажилчдын тэтгэмжийн төлөвлөгөөний олз/гарз хамаарна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

2.18 Зээлийн өртөг

Хугацаа шаардсан хөрөнгийн худалдаж авах, барьж байгуулах, үйлдвэрлэхтэй шууд холбоотой зээлийн зардлыг тухайн хөрөнгө иж бүрэн, ашиглахад бэлэн болох хүртэлх хугацаанд капиталжуулдаг. Тухайн зорилгоор авсан зээлтэй холбоотой хүүгийн түвшин эсвэл Компанийн зээлийн ерөнхий эх үүсвэр нь ашиглагдаж буй бол жигнэсэн дундаж хүүгийн түвшнээр санхүүгийн зардлыг капиталжуулдаг. Зээлийн өртгийн капиталжуулалт нь хөрөнгийн барьж босгох үйл явц зогссон үед дуусдаг. Бусад зээлийн өртөг нь тухайн зардал гарсан үеийн санхүүгийн зардалд тайлагнагддаг.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.19 Тайлант жилийн болон хойшлогдсон татвар

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлогдлсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагддаг. Компанийн тайлант жилийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцогдох бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан дүн мөн багтсан болно.

Санхүүгийн байдлын тайланд тусгасан хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь татварын сууриас зөрүүтэй байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрдөг. Харин дараах зүйлсээс үүссэн зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр гэж үзэхгүй:

- Тухайн ажил гүйлгээ гарсан үедээ нягтлан бодох бүртгэлийн эсвэл татварын ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, бизнесийн нэгдлийн бус ажил гүйлгээний хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт, ба
- Гарсан зөрүүнд буцаалт хийх хугацааг Компани хянах чадвартай охин компани болон хамтарсан хэлэлцээрт оруулсан хөрөнгө оруулалт ба тухайн зөрүүг ойрын ирээдүйд буцаахгүй байх магадлалтай байх.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

Хөрөнгө эсвэл өр төлбөрийн татварын суурь, тодорхой ажил гүйлгээний татвар ногдох байдал, эсвэл татвартай холбоотой бусад төсөөлөлтэй холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд Компани нь:

- Тодорхой бус татварын байр суурийг тусад нь эсвэл багцлан авч үзэх эсэх (шийдвэрлэлтийг нь хамгийн сайн таамаглаж чадах аргад үндэслэн); ба
- Тодорхой бус татварын байр суурийг татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтын эсэхийг тодорхойлох.

Тодорхой бус татварын байр суурийг хүлээн зөвшөөрөх магадлалгүй бол тодорхой бус байдлын шийдвэрлэлтийг хамгийн сайн таамаглах аргаас хамаарч хамгийн боломжит үнийн дүн эсвэл таамагласан үнэ цэний аргад үндэслэн тодорхой бус татварын байр суурийг хэмжинэ. Энэхүү хэмжилтийг хийхийн тулд татварын алба тус бүр өөрсдийн шалгах эрхтэй бүхий л үнийн дүнг шалгах бөгөөд эдгээр шалгалтыг хийхдээ холбогдох бүх мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна гэсэн төсөөлөлд суурилахыг шаарддаг.

Компани нь тайлант жилийн татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэрлэх хуульд заасан эрхтэй бөгөөд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь нэг ижил татварын эрх бүхий байгууллагад ногдуулсан татвартай дараах нөхцөлийн аль нэг байдлаар холбоотой байгаа бол хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь цэвэрлэнэ:

- Татвар ногдуулах ижил байгууллага; эсвэл
- Татвар ногдуулах ялгаатай байгууллагаас цэвэр сууриар тайлант үеийн өр төлбөр ба хөрөнгийг барагдуулах эсвэл ирээдүйн тайлант үе бүрд барагдуулахаар буюу нөхөхөөр төлөвлөсөн хойшлогдсон татварын өр төлбөр буюу хөрөнгийн нөлөө бүхий дүнгээр хөрөнгийг хүлээн авсан ба өр төлбөрийг нэгэн зэрэг барагдуулахаар төлөвлөсөн.

2.20 Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох ашиг нь компанийн тайлант жилийн турш эргэлтэд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваарилагдсан цэвэр ашиг, алдагдлаар тооцоологддог. Энэ нь энгийн хувьцаа нэг бүрд ногдох тайлант жилийн ашиг, алдагдлын дүнг илэрхийлнэ. Компани аливаа хорогдуулагч хэрэглүүр эзэмшдэг бол нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашгийн тооцоог мөн хийж тайлагнана.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.21 Ажилчдын тэтгэмж

2.21.1 Богино хугацааны ажилчдын тэтгэмж

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг. Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

2.21.2 Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

2.22 Урьдчилгаа төлбөр

Бэлтгэн нийлүүлэгчдэд болон бусад талуудад урьдчилан төлсөн ирээдүйд зардлаар эсвэл хөрөнгөөр хаагдах мөнгөн бус хөрөнгийг өртгөөр нь хуримтлуулан бүртгэж санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгө хэсэгт тайлагнана.

2.23 Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.24 Засгийн газрын буцалтгүй тусламж

Засгийн газрын буцалтгүй тусламж гэдэг нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой нөхцөлүүдийг өнгөрсөн үед эсвэл ирээдүйд даган мөрдөлтийн хариу болгон уг аж ахуйн нэгжид нөөцийн шилжүүлэлт хэлбэрээр Засгийн газраас үзүүлж буй туслалцаа юм.

Дараах нөхцөл нь ул үндэслэлтэйгээр баталгаатай болох хүртэл засгийн газрын буцалтгүй тусламжийг, үүн дотроо бодит үнэ цэнэ бүхий мөнгөн зүйлсийн бус буцалтгүй тусламжийг хүлээн зөвшөөрөхгүй:

- Аж ахуйн нэгж нь буцалтгүй тусламжид хамаарах нөхцөлүүдийг хангах; мөн
- Буцалтгүй тусламжийг хүлээн авах.

Буцалтгүй тусламжийн хүлээн авалт нь уг буцалтгүй тусламжид хамаарах нөхцөлүүдийг хангасан эсвэл хангана гэсэн дүгнэлтийн шинжтэй нотолгоог дангаараа бүрдүүлэхгүй.

Компани тавигдсан шалгуурыг хангаж чадах эсэхээс засгийн газрын буцалтгүй тусламж авах эсэх нь хамаардаг тул түүнийг анх хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрдөг. Харин буцалтгүй тусламжийн шалгуурыг хангасны дараа хойшлогдсон орлогын үлдэгдлийг холбогдох зардалтай уялдуулан ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Ингэхдээ буцалтгүй тусламжийг Компани холбогдох зардалтай нь цэвэрлэж цэвэр дүнгээр тайлагнадаг.

2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.25 Холбоотой талууд

Хэрэв тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно.

a) Аливаа хувь хүн эсвэл түүний ойр дотнын гэр бүлийн гишүүнийг дараах тохиолдлуудад Компанийн хувьд холбоотой тал гэж үзнэ. Хувь хүн нь:

- Компанийг хянадаг эсвэл хамтын хяналттай бол;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй бол; эсвэл
- Компани эсвэл түүний толгой компанийн гол удирдлагын багийн гишүүний нэг бол.

b) Компанийг дараах тохиолдлуудад нөгөө компанийн холбоотой тал гэж үзнэ:

- Нэг групп компанийн бүрэлдэхүүн компаниуд хоорондоо холбоотой талууд байна;
- Компани нь нөгөө компанийнхаа хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол (эсвэл Компани нь нөгөө компанийн харьяалагддаг группийн өөр нэг гишүүн компанийн хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол);
- Хоёр компани хоёулаа нэг ижил гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд бол;
- Компани нь гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба нөгөө компани нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Компани нь нөгөө компанийн эсвэл түүнтэй холбоотой компанийн ажиллагсдын ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхэлдэг бол;
- (а)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө Компанид хяналт эсвэл хамтын хяналттай бол; эсвэл
- (а)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй, эсвэл нөгөө компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.

Холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хоорондын харилцааг тодруулах ёстой.

Холбоотой талуудын ажил гүйлгээний тодруулгад дараах зүйлсийг тодруулна.

- Худалдан авалт;
- Борлуулалт;
- Түрээс;
- Зээл;
- Баталгаа, барьцааны нөхцөлүүд;
- Хэрэв ирээдүйд тодорхой нэг үйл явдал хэрэгжих эсвэл хэрэгжээгүй үед ямар нэг үүрэг хүлээх амлалт; болон
- Аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс эсвэл холбоотой талын нэрийн өмнөөс аж ахуйн нэгж өр төлбөрийг барагдуулах.

Компанийн санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

3. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Ирээдүйд бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Дараагийн санхүүгийн жилүүдэд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг нөлөө үзүүлж болохуйц нөлөө бүхий эрсдэлтэй тооцоолол ба төсөөллийг доор дурдав.

3.1 Үнэлэмж

- Гүйцэтгэлийн үүргүүдийн биелэлтийн хугацаа (Тодруулга 18 – Харилцагчидтай хийсэн гэрээний орлогоос харна уу).

3.2 Таамаглал, тооцоолол

- Зээлийн өртөг – Хугацаа шаардах хөрөнгө барьж байгуулахад ашигласан зээлийн хүүгийн капиталжуулалт (Тодруулга 10);
- Санхүүгийн өр төлбөрийн хэмжилт – Хөнгөлөлттэй нөхцөл бүхий урт хугацаат зээлийн анхны хүлээн зөвшөөрөлт болон дараа үеийн хэмжилт (Тодруулга 15);
- Засгийн газрын буцалтгүй тусламж ба туслалцаа – Хөнгөлөлттэй зээлээр дамжуулан Засгийн газраас хүлээн авсан буцалтгүй тусламж (Тодруулга 15 ба 24);
- Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт – Хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол (Тодруулга 6);
- Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэний бууралт – Хөрөнгийн дансны үнийн нөхөгдөх дүнгээс давсан хэсэг (Тодруулга 10, 11 ба 12);
- Орлого хүлээн зөвшөөрөлт – Хэрвээ худалдан авагч сэтгэл хангалуун бус байвал бараа буцаах эрхийн нөөц болон хөнгөлөлтийн түвшин (Тодруулга 8 ба 18);
- Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ – Тооцоолсон борлуулалтын үнээс борлуулахад бэлэн болгоход шаардлагатай тооцоолсон гүйцээх өртгөг болон борлуулалтын зардлыг хассан үнэ цэнэ (Тодруулга 8);
- Орлогын албан татвар – Орлогын татварын хуулийн зүйл заалтыг хэрэглэсэн үндэслэл дэх орлогын татварын нөөц (Тодруулга 17);
- Компани түрээслэгчээр оролцож буй түрээсийн гэрээний хувьд түрээсийн хугацаа тодорхойлох, үүнд, Компани түрээслэгчийн сонголтыг хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэй эсэх (Тодруулга 11);
- Түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд ашигласан өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн тооцоолол (Тодруулга 11); болон
- Элэгдэх хөрөнгийн ашиглалтын жил болон элэгдүүлэх арга – Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгийг системчилсэн сууриар элэгдүүлэлт (Тодруулга 10, 11 ба 12).

4. Шинэ болон шинэчлэгдсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд

4.1 Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд болон шинэ тайлбарууд

Компани нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2025 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2025 оны 1 сарын 1	• *НББОУС 21 Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-д орсон өөрчлөлт – Валютын Солилцоо Хийгдэхгүй байх

Дээр дурдсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын хэрэгжилт нь Компанийн санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудад нөлөө үзүүлээгүй болно.

4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй шинэчлэгдсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд болон стандартын өөрчлөлтүүд:

Компанийн санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа шинэ СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд болон стандартын өөрчлөлтүүдийг доор тодруулсан болно. Эдгээр стандартууд болон өөрчлөлтүүдийг Компани хэрэгжиж эхлэх үеэс дагаж мөрдөнө.

Хэрэгжих эхлэх хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2026 оны 1 сарын 1	• *СТОУС 9 болон СТОУС 7-н Санхүүгийн Хэрэглүүрийн Хэмжилт болон Ангилалд орсон өөрчлөлт* • *СТОУС-н Жил Бүрийн Сайжруулалт – 11 дэх удаа*
2027 оны 1 сарын 1	• *СТОУС 18 Санхүүгийн Тайлангуудын Толилуулга ба Тодруулга* • *СТОУС 19 Олон Нийтийн Өмнө Үүрэг Хүлээдэггүй Охин компаниуд – Тодруулга*
Тодорхойгүй	• СТОУС 10 болон НББОУС 28-т орсон нэмэлт өөрчлөлтүүд *Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсвэл хандивласан хөрөнгө*

Компанийн удирдлага нь эдгээр шинэ СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд болон стандартын өөрчлөлтүүдийг нэвтрүүлэх явцад хяналт тавин ажиллаж байна. Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг тодорхойлж дуусаагүй байгаа хэдий ч Компанийн удирдлага эдгээр шинэ стандартууд, стандартад орсон өөрчлөлтүүдийн нөлөөлөл нь Компанийн нягтлан болох бүртгэлийн бодлого, санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд материаллаг нөлөөлөхгүй гэж үзэж байна.

5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

	2025	2024
Касс дахь мөнгө	17,354	47,934
Банкны харилцах данс дахь мөнгө	35,831	2,244,454
	53,185	**2,292,388**

6. Дансны ба бусад авлага

	2025	2024
Дансны авлага	5,095,201	3,990,803
Дансны авлага – Холбоотой тал[1] (Тодруулга 26)	2,019,658	1,455,117
Бусад авлага	505,172	300,499
	7,620,031	**5,746,419**
Авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц сан	(186,367)	(248,977)
	7,433,664	**5,497,442**

(1) Холбоотой талаас авах авлага нь орон нутаг дахь Монос Группийн хөдөө орон нутаг дахь холбоотой компаниуд болон Монос-Улаанбаатар ХХК-ийн эмийн сангуудад зээлээр борлуулалт хийснээс үүссэн дүн бөгөөд уг авлага нь гэрээний дагуу 60 хоногийн дотор цуглуулагдах нөхцөлтэй.

6.1 Авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц сан

Хугацаа хэтэрсэн авлагад хүү тооцдоггүй. Аливаа шинэ харилцагчийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө Компанийн удирдлага харилцагчийн зээлийн эрсдэлийн чанарыг үнэлэн зээлийн хязгаарыг харилцагч тус бүрийн хувьд тодорхойлдог.

Компани дансны авлагын алдагдлын нөөц санг бүртгэхдээ нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолдог. Тайлагналын өдрөөр авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо алдагдлын түүхэн мэдээлэл, тухайн зээлдэгчид тусгайлан хамааралтай хүчин зүйлс, үндсэн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн орчин, одоогийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг харгалзан тохируулсан нөөц сан тооцоолох матрицыг (үнэ цэнэ нь буураагүй авлагуудад) болон тусгайлсан үнэлгээний аргыг (үнэ цэнэ буурсан авлагад) ашигладаг.

Тооцооллын арга аргачлал болон нөлөө үзүүлэхүйц таамаглалуудад тайлант жилд өөрчлөлт ороогүй болно.

6. Дансны ба бусад авлага (үргэлжлэл)

6.1 Авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц сан (үргэлжлэл)

2025 оны 12-р сарын 31-нээрх дансны авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц нь дараах байдалтай байна:

	Хугацаа хэтрээгүй	31-60 хоног	61-120 хоног	121-180 хоног	181-360 хоног	361-ээс дээш хоног	Нийт
Хүлээгдэж буй алдагдлын хувь	0.53%	1.00%	2.00%	5.00%	50.00%	100.00%	**2.45%**
Нийт дансны үнэ	3,458,965	1,986,480	1,790,628	243,223	80,968	59,767	**7,620,031**
Алдагдлын нөөц	**18,277**	**19,865**	**35,813**	**12,161**	**40,484**	**59,767**	**186,367**

2024 оны 12-р сарын 31-нээрх дансны авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц нь дараах байдалтай байна:

	Хугацаа хэтрээгүй	31-60 хоног	61-120 хоног	121-180 хоног	181-360 хоног	361-ээс дээш хоног	Нийт
Хүлээгдэж буй алдагдлын хувь	1.24%	1.00%	2.00%	5.83%	50.01%	100.00%	**4.33%**
Нийт дансны үнэ	3,118,998	1,575,766	838,193	35,730	3,867	173,865	**5,746,419**
Алдагдлын нөөц	**38,533**	**15,768**	**16,794**	**2,083**	**1,934**	**173,865**	**248,977**

7. Урьдчилгаа

	2025	2024
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр	469,668	399,054
Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн урьдчилгаа	67,716	1,065,216
Урьдчилж төлсөн зардал	128,510	101,617
Урьдчилж төлсөн НӨАТ[(1)]	2,589,595	1,929,898
	3,255,489	**3,495,785**

(1) Үндсэн хөрөнгөд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг Монгол Улсын Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын тухай хуульд заасны дагуу 5-10 жилийн хугацаанд хорогдуулна.

	2025	2024
Эргэлтийн	962,238	544,383
Эргэлтийн бус	2,293,251	2,951,402
	3,255,489	**3,495,785**

8. Бараа материал

	2025	2024
Түүхий эд материал	3,078,756	4,091,925
Бэлэн бүтээгдэхүүн	3,330,781	1,929,843
Хангамжийн материал	1,414,223	546,241
Замд яваа бараа	55,123	1,140,382
Буцаагдахаар тооцсон бараа материал	161,925	125,302
Бараа материалын үнэ цэний бууралтын хасагдуулга	-	(26,957)
	8,040,808	**7,806,736**

8.1 Буцаагдахаар тооцсон бараа материал

	2025	2024
1 сарын 1 үлдэгдэл	**125,302**	**115,302**
Буцаах эрхтэй хөрөнгөөр нэмж хүлээн зөвшөөрсөн дүн	36,623	10,000
12 сарын 31 үлдэгдэл	**161,925**	**125,302**

8.2 Нөөц өр төлбөр

	2025	2024
Борлуулалтын хөнгөлөлтийн нөөц[1]	-	8,101
Бараа материалын буцаалтын нөөц[2]	270,203	231,014
	270,203	**239,115**

(1) Компанийн хүлээн зөвшөөрсөн нөөцийн дүн нь тайлант онд худалдан авагчидтай байгуулсан гэрээнд заасан хөнгөлөлтийн нөхцөлөөс 2025 онд хөнгөлөлт эдлэх магадлалд үндэслэж тооцоолсон дүнг илэрхийлнэ.

(2) Тайлант онд буцаах эрхтэй хийгдсэн борлуулалтын орлогоос 2025 онд буцаалт үүсэх магадлалд үндэслэж тооцоолсон дүнг илэрхийлнэ. Тайлант хугацаанд шинэчлэн тооцсон буцаалтын хувьд өсөлт гарсан тул борлуулалтын буцаалтын нөөц болон буцааж авах бараа материалыг хүлээн зөвшөөрсөн. Буцаалт үүсэх үед ихэвчлэн өмнө нь хүлээн зөвшөөрсөн худалдааны авлагыг үл хүлээн зөвшөөрдөг бөгөөд ховор тохиолдолд мөнгөн төлөлтөөр буцаалтыг барагдуулдаг.

8.3 Барьцаалсан бараа материал

2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрхбараа материалын үлдэгдэлийг бүхэлд нь Голомт банкны зээлд барьцаалсан.

9. Бусад эргэлтийн хөрөнгө

	2025	2024
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	-	1,428,799
	-	**1,428,799**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 06/2024 тоот тогтоолоор Компани хуучин үйлдвэрийн барилга, байгууламжийг борлуулах шийдвэр гаргасан. Энэхүү хуучин үйлдвэрийн барилга, байгууламж болон тоног төхөөрөмжийг 2025 оны 4 сарын 17-нд 4,450,000 мянган төгрөг (НӨАТ орсон үнэ)-р борлуулж 2,611,015 мянган төгрөгийн олз хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

10. Үндсэн хөрөнгө

	Газрын сайжруулалт	Барилга, байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Дуусаагүй барилга	Бусад	Нийт
Өртөг:									
2023 оны 12 сарын 31	**1,488**	**7,841,654**	**9,262,262**	**472,643**	**913,903**	**446,659**	**22,936,773**	**5,550**	**41,880,932**
Олж эзэмшсэн	-	107,854	359,509	-	443,681	89,346	1,736,237	-	2,736,627
Капиталжуулсан хүү	-	-	-	-	-	-	1,700,827	-	1,700,827
Шилжүүлсэн	-	24,592,251	1,534,608	-	-	18,400	(26,145,259)	-	-
Данснаас хассан	-	-	(281,762)	-	(36,011)	(20,893)	-	-	(338,666)
Бусад эргэлтийн хөрөнгөд ангилсан (Тодруулга 9)	(1,488)	(1,977,351)	-	-	-	-	-	-	(1,978,839)
2024 оны 12 сарын 31	**-**	**30,564,408**	**10,874,617**	**472,643**	**1,321,573**	**533,512**	**228,578**	**5,550**	**44,000,881**
Олж эзэмшсэн	-	102,484	577,932	-	78,160	81,015	3,888,539	-	4,728,130
Капиталжуулсан хүү	-	-	-	-	-	-	148,064	-	148,064
Данснаас хассан	-	-	(239,230)	-	(60,720)	(29,082)	-	-	(329,032)
2025 оны 12 сарын 31	**-**	**30,666,892**	**11,213,319**	**472,643**	**1,339,013**	**585,445**	**4,265,181**	**5,550**	**48,548,043**
Хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэний бууралт:									
2023 оны 12 сарын 31	**706**	**1,029,788**	**5,995,662**	**81,074**	**680,826**	**358,084**	**-**	**2,821**	**8,148,961**
Элэгдэл	50	406,598	627,144	55,457	128,533	63,615	-	555	1,281,952
Данснаас хассан	-	-	(281,210)	-	(35,933)	(18,235)	-	-	(335,378)
Бусад эргэлтийн хөрөнгөд ангилсан (Тодруулга 9)	(756)	(549,284)	-	-	-	-	-	-	(550,040)
2024 оны 12 сарын 31	**-**	**887,102**	**6,341,596**	**136,531**	**773,426**	**403,464**	**-**	**3,376**	**8,545,495**
Элэгдэл	-	1,237,525	757,419	55,457	156,399	82,185	-	555	2,289,540
Данснаас хассан	-	-	(233,790)	-	(60,466)	(29,082)	-	-	(323,338)
2025 оны 12 сарын 31	**-**	**2,124,627**	**6,865,225**	**191,988**	**869,359**	**456,567**	**-**	**3,931**	**10,511,697**
Дансны үнэ:									
2024 оны 12 сарын 31	**-**	**29,677,306**	**4,533,021**	**336,112**	**548,147**	**130,048**	**228,578**	**2,174**	**35,455,386**
2025 оны 12 сарын 31	**-**	**28,542,265**	**4,348,094**	**280,655**	**469,654**	**128,878**	**4,265,181**	**1,619**	**38,036,346**

10. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Компани MFC 2.0 төслийн шинэ үйлдвэрийн барилгын ажлыг 2022 онд эхлүүлсэн ба 2024 оны 11 дүгээр сард үйлдвэрийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг барих, суурилуулах ажил дуусаж, ашиглалтад оруулсан. Компани шинэ үйлдвэрийн барилгад зориулан тусгайлан үйлдвэрлэгдсэн, барилгаас салган, өөр газар ашиглах боломжгүй, үйлдвэрийн хана болон тусгайлан хийгдсэн барилгын хэсгүүдэд бэхлэгдэн ажилладаг тоног төхөөрөмжүүдийг барилга, байгууламжид ангилсан.

Шинэ үйлдвэрийг иж бүрэн барьж, ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлсэн.

Компани East Log төслийн шинэ зүүн бүсийн агуулахын барилгын ажлыг 2025 онд эхлүүлсэн ба 2026 оны 2 дугээр улиралд агуулахын барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг барих, суурилуулах ажил дуусаж, ашиглалтад оруулна гэж төлөвлөж байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дуусаагүй барилгын өртөг нь одоо баригдаж буй зүүн бүсийн агуулахын өртгөөс бүрдэж байна. Тайлант жилд капиталжуулсан зээлийн өртөг 148,064 мянган төгрөг байна.

Компани тайлант жилийн нийт элэгдлээс 205,349 мянган төгрөг (2024: 184,078 мянган төгрөг)-ийг удирдлагын зардлаар, 99,758 мянган төгрөг (2024: 60,893 мянган төгрөг)-ийг борлуулалтын зардлаар мөн 1,984,433 мянган төгрөг (2024: 1,036,981 мянган төгрөг)-ийг бараа материалын өртөгт хүлээн зөвшөөрсөн байна.

Компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хэдий ч бүрэн элэгдсэн хөрөнгийн нийт дансны үнэ нь 4,658,342 мянган төгрөг (2024: 4,746,907 мянган төгрөг) байна.

10.1 Барьцаалсан үндсэн хөрөнгө

2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр нийт 5,572,016 мянган төгрөг (2024: 5,725,561 мянган төгрөг)-ийн дансны үнэ бүхий барилгыг банкны зээлд барьцаалсан (Тодруулга 15-г харна уу). Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу шинэ үйлдвэрийн барилгыг улсын бүртгэлийн гэрчилгээ гармагц газрын хамт банкны зээлд нөхөн барьцаална.

11. Түрээс

Компани нь түрээслүүлэгч аж ахуйн нэгжүүдээс агуулах, оффис болон Монгол улсын төрөөс газар түрээсэлдэг. Уг түрээснүүд нь түрээсийн хугацаанд төлөх тогтмол төлбөрүүдээс бүрдэнэ. Компани нь түрээсийн өр төлбөрийг өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглан түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн. Зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшин гэдэг нь ижил хугацаа, нөхцөлтэйгөөр бие даасан зээлдүүлэгчээс ижил зээл авсан үед төлөх хүүгийн түвшин юм. Ашигласан зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшин нь агуулахын түрээсийн хувьд 14.2 хувь, газрын түрээсийн хувьд 11 хувь байсан.

11.1 Ашиглах эрхтэй хөрөнгө

	Газар	Агуулах	Оффис	Нийт
Дансны үнэ:				
2023 оны 12 сарын 31	**740,015**	**227,474**	**-**	**967,489**
Нэмэгдсэн	1,766,963	-	-	1,766,963
Элэгдэл	(17,265)	(113,752)	-	(131,017)
Түрээсийн нөхцөл өөрчилсний нөлөө	-	(881)	-	(881)
Данснаас хассан	(12,897)	-	-	(12,897)
2024 оны 12 сарын 31	**2,476,816**	**112,841**	**-**	**2,589,657**
Нэмэгдсэн	1,333,803	-	305,554	1,639,357
Элэгдэл	(119,589)	(27,901)	(238,959)	(386,449)
Данснаас хассан	-	(84,940)	-	(84,940)
2025 оны 12 сарын 31	**3,691,030**	**-**	**66,595**	**3,757,625**

11. Түрээс (үргэлжлэл)

11.1 Ашиглах эрхтэй хөрөнгө (үргэлжлэл)

Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн:

	2025	2024
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	27,327	32,868
Түрээсийн нөхцөл өөрчилсний олз	-	16,259
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	3,446	922
Богино хугацаат түрээсийн зардал	1,700,852	1,078,599

Компани тайлант жилийн элэгдэл 46,741 мянган төгрөг (2024: 131,017 мянган төгрөг)-ийг бараа материалын өртөгт хүлээн зөвшөөрсөн ба 339,708 мянган төгрөг (2024: 0 мянган төгрөг)-ийг ерөнхий ба удирдлагын зардал болон борлуулалт ба маркетингийн зардалд хүлээн зөвшөөрсөн байна. 2025 оны 12 дугаар сарын 31-нээр 2,389,048 мянган төгрөгийн (2024: 724,399 мянган төгрөг) газар эзэмших эрхийг банкны зээлд барьцаалсан.

11.2 Түрээсийн өр төлбөр

	Газар	Агуулах	Оффис	Нийт
2023 оны 12 сарын 31	**31,418**	**238,104**	**-**	**269,522**
Нэмэгдсэн	45,321	-	-	45,321
Түрээсийн нөхцөл өөрчилсний нөлөө	-	(17,140)	-	(17,140)
Данснаас хассан	(13,819)	-	-	(13,819)
Хүүгийн зардал	9,108	23,760	-	32,868
Түрээсийн төлбөр	(4,632)	(128,893)	-	(133,525)
2024 оны 12 сарын 31	**67,396**	**115,831**	**-**	**183,227**
Нэмэгдсэн	38,349	-	200,875	239,224
Данснаас хассан	-	(88,387)	-	(88,387)
Хүүгийн зардал	10,287	3,790	13,250	27,327
Түрээсийн төлбөр	(11,913)	(31,234)	(214,125)	(257,272)
2025 оны 12 сарын 31	**104,119**	**-**	**-**	**104,119**

	2025	2024
Богино хугацаат	1,624	116,255
Урт хугацаат	102,495	66,972
	104,119	**183,227**

12. Биет бус хөрөнгө

	Программ хангамж	Патент	Барааны тэмдэг	Хөгжүүлэлт-ийн зардал	Бусад	Нийт
Өртөг:						
2023 оны 12 сарын 31	**219,565**	**7,281**	**393,918**	**77,255**	**14,496**	**712,515**
Нэмэгдсэн	4,300	-	-	-	17,273	21,573
2024 оны 12 сарын 31	**223,865**	**7,281**	**393,918**	**77,255**	**31,769**	**734,088**
Нэмэгдсэн	44,508	-	1,350	-	-	45,858
2025 оны 12 сарын 31	**268,373**	**7,281**	**395,268**	**77,255**	**31,769**	**779,946**
Хуримтлагдсан хорогдол:						
2023 оны 12 сарын 31	**165,248**	**2,616**	**116,110**	-	**14,496**	**298,470**
Хорогдол	50,596	451	52,223	-	5,278	108,548
2024 оны 12 сарын 31	**215,844**	**3,067**	**168,333**	-	**19,774**	**407,018**
Хорогдол	13,608	451	53,573	-	7,197	74,829
2025 оны 12 сарын 31	**229,452**	**3,518**	**221,906**	-	**26,971**	**481,847**
Дансны үнэ:						
2024 оны 12 сарын 31	**8,021**	**4,214**	**225,585**	**77,255**	**11,995**	**327,070**
2025 оны 12 сарын 31	**38,921**	**3,763**	**173,362**	**77,255**	**4,798**	**298,099**

Дотооддоо бий болгож буй биет бус хөрөнгөд хөгжүүлэлтийн зардлыг хуримтлуулан бүртгэдэг ба тайлант жилд хөгжүүлэлтийн зардалд хөдөлгөөн гараагүй байна.

Биет бус хөрөнгийн хорогдлоос 63,688 мянган төгрөг (2024: 103,400 мянган төгрөг)-ийг удирдлагын зардлаар, 10,015 мянган төгрөг (2024: 0 мянган төгрөг)-ийг борлуулалт ба маркетингийн зардлаар, 1,126 мянган төгрөг (2024: 5,148 мянган төгрөг)-ийг борлуулалтын бүтээгдэхүүний өртгөөр хүлээн зөвшөөрсөн байна.

13. Дансны болон бусад өглөг

	2025	2024
Дансны өглөг	1,195,601	1,495,806
Бусад өглөг	1,237,949	1,199,579
Хуримтлуулж тооцсон өр	1,348,220	649,178
Холбоотой талд өгөх өглөг (Тодруулга 26)	28,318	35,115
Бусад татвар болон нийгмийн даатгалын төлбөр	1,104,877	569,713
	4,914,965	**3,949,391**

14. Гэрээний өр төлбөр

	2025	2024
1 сарын 1-ний үлдэгдэл	93,651	48,499
Тайлант хугацаанд гэрээний өр төлбөрөөс хүлээн зөвшөөрсөн орлого	(284,279)	(160,956)
Тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй гүйцэтгэлд урьдчилж авсан мөнгө	321,344	206,108
12 сарын 31-ний үлдэгдэл	**130,716**	**93,651**

(1) Практик чөлөөлөлт

Компани нь амласан бараа, үйлчилгээг худалдан авагчид нийлүүлсэн өдөр бараа, үйлчилгээний үнийг худалдан авагч төлөх өдрийн хоорондох хугацаа нь нэг жил буюу түүнээс богино байна гэж хүлээж байгаа учир санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсгийн нөлөөллийг практик чөлөөлөлт болгон аливаа тохируулга хийхгүй байх сонголтыг хийсэн.

15. Зээл

Зээлийн нэрлэсэн үнэ болон хорогдуулсан өртөг нь дараах байдалтай байна:

	2025		2024	
	Нэрлэсэн үнэ	**Хорогдуул-сан үнэ**	**Нэрлэсэн үнэ**	**Хорогдуул-сан үнэ**
Урт хугацаат:				
Банкны зээл	18,600,000	17,333,220	15,975,000	13,507,432
	18,600,000	**17,333,220**	**15,975,000**	**13,507,432**
Богино хугацаат:				
Банкны зээл	7,105,000	5,966,648	14,625,080	12,979,016
	7,105,000	**5,966,648**	**14,625,080**	**12,979,016**
	25,705,000	**23,299,868**	**30,600,080**	**26,486,448**

Компанийн зээлийн багцыг зээл авсан валютаар дараах хүснэгтэд харуулав:

Зээлдүүлэгч	**Валют**	**2025**	**2024**
Голомт Банк	Төгрөг	6,000,000	5,000,000
Худалдаа Хөгжлийн Банк	Төгрөг	19,705,000	25,600,080
		25,705,000	**30,600,080**

Энэ тодруулгад хүү тооцогддог бөгөөд хорогдуулсан өртгөөр нь бүртгэдэг зээлийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг оруулсан. Эдгээр зээлээс үүсэх хүүгийн түвшин, гадаад валют ба төлбөрийн чадварын эрсдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 27-аас үзнэ үү.

		2025	2024
Урт хугацаат:			
Голомт банкнаас авсан зээл	(2)	6,000,000	-
Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл	(5)	3,699,687	4,374,062
Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл	(6)	7,633,533	9,133,370
		17,333,220	**13,507,432**

15. Зээл (үргэлжлэл)

Богино хугацаат:

Голомт банкнаас авсан зээл	(1)	-	5,000,000
Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл	(3)	-	950,549
Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл	(4)	-	6,163,299
Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл	(5)	674,376	213,008
Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл	(6)	1,499,836	619,805
Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл	(7)	3,730,000	-
Хүүгийн өглөг		62,436	32,355
		5,966,648	**12,979,016**
		23,299,868	**26,486,448**

15.1 Зээлийн гэрээний хураангуй:

(1) Голомт Банкнаас авсан зээл
2023 оны 11-р сарын 29-нд Монос Групп болон түүний хамааралтай компаниудын Голомт Банктай байгуулсан "Зээл, баталгаа, факторингийн баталгаа, аккредитив, аккредитивын дараах санхүүжилт, импортын зээлийн үйлчилгээ үзүүлэх зээл"-ийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 1 жилийн хугацаатай, жилийн 15.7 хувийн хүүтэй, нийт 48 тэрбум төгрөгийн зээл, баталгаа, факторингийн баталгаа, аккредитив, аккредитивын дараах санхүүжилт, импортын зээл олгох нөхцөлтэй болгон өөрчлөлт оруулсан.

2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Монос Групп болон түүний хамааралтай компаниуд Голомт Банктай нийт 10 тэрбум төгрөг хүртэл зээлийн эрх бүхий "Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээ"-г 2 жилийн хугацаатай, 16.2 хувийн хүүтэй байгуулсан. 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр өмнөх зээлийн гэрээг дуусган, Групп шинээр 1 жилийн хугацаатай, 15.2 хувийн хүүтэй, нийт 40 тэрбум төгрөгийн зээлийн эрх бүхий "Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээ"-г байгуулсан.

Зээлийг 2025 оны 4 дугаар сарын 9-нд бүрэн төлж дууссан.

(2) Голомт Банкнаас авсан зээл
2025 оны 12-р сарын 11-ний өдөр байгуулсан ЗГ8125103184 тоот гэрээгээр зүүн бүсийн шинэ агуулахын барилгын төслийн санхүүжилтэд ашиглах зорилгоор Монгол банкны нийтэд зарласан бодлогын хүү дээр нэмэх нь 3 хувийн хүүтэй, 2032 оны 12-р сарын 3-ний өдөр хүртэл хугацаатай, 6,000,000 мянган төгрөгийн зээл авсан.

(3) Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл
Худалдаа Хөгжлийн Банктай 2023 оны 05-р сарын 18-ны өдөр байгуулсан ЗГ/СС230511009-53 тоот гэрээгээр эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (цаашид 'ХХААХҮЯ' гэх) -ны хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5 хувийн хүүтэй 3,000,000 мянган төгрөгийн зээл авсан. Зээлийн хугацаа 24 сар. Банкны энгийн нөхцөлөөр зээлийн хүү жилийн 17.2 хувь бөгөөд зөрүү 12.2 хувийн хүүг Засгийн Газраас хариуцан төлнө.

Зээлийг 2025 оны 5 дугаар сарын 8-нд бүрэн төлж дууссан.

15. Зээл (үргэлжлэл)

15.1 Зээлийн гэрээний хураангуй (үргэлжлэл)

(4) Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл
Худалдаа Хөгжлийн Банктай 2023 оны 12-р сарын 26-ны өдөр байгуулсан ЗГ/СС230511009-63 тоот гэрээгээр эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор ХХААХҮЯ-ны хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5 хувийн хүүтэй 9,000,000 мянган төгрөгийн зээл авсан. Зээлийн хугацаа 24 сар. Банкны энгийн нөхцөлөөр зээлийн хүү жилийн 18 хувь бөгөөд зөрүү 13 хувийн хүүг Засгийн Газраас хариуцан төлнө.

Зээлийг 2025 оны 12 дугаар сарын 30-нд бүрэн төлж дууссан.

(5) Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл
Худалдаа Хөгжлийн Банктай 2023 оны 12-р сарын 26-ны өдөр байгуулсан ЗГ/СС230511009-62 тоот гэрээгээр хөрөнгө оруулалтын зориулалттайгаар ХХААХҮЯ-ны хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 6 хувийн хүүтэй 6,000,000 мянган төгрөгийн зээл авсан. Зээлийн хугацаа 60 сар. Банкны энгийн нөхцөлөөр зээлийн хүү жилийн 18 хувь бөгөөд зөрүү 12 хувийн хүүг Засгийн Газраас хариуцан төлнө. Компани зээлийн гэрээний нөхцөлийг дагаж мөрдөөгүй тохиолдолд зээлийн хүүгийн хөнгөлөлтийг цуцалж, банкны энгийн нөхцөлтэй зээлд шилжүүлнэ. Түс зээлийн гэрээний хүрээнд ХХААХҮЯ болон Худалдаа Хөгжлийн Банктай "Хүнсний болон Хөдөө Аж Ахуйн Үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл"-ийн хүнсний болон боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид олгосон зээлд хяналт тавих гэрээг байгуулсан бөгөөд компани нь зээлийн хэрэгжилтийн тайланг хүснэгтийн дагуу улирал бүр, зээлийн зарцуулалтын тайланд зээлийн хөрөнгийн гүйлгээтэй холбогдох гэрээний жагсаалтыг тусгаж, дансны хуулгыг хавсарган жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор яаманд хүргүүлэх үүрэг хүлээнэ. Засгийн газрын бүцалтгүй тусламжийн орлогыг Тодруулга 24-аас үзнэ үү.

(6) Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл
Худалдаа Хөгжлийн Банктай 2023 оны 12-р сарын 26-ны өдөр байгуулсан ЗГ/СС230511009-61 тоот гэрээгээр хөрөнгө оруулалтын зориулалттайгаар ХХААХҮЯ-ны хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 6 хувийн хүүтэй 12,000,000 мянган төгрөгийн зээл авсан. Зээлийн хугацаа 60 сар. Банкны энгийн нөхцөлөөр зээлийн хүү жилийн 15 хувь бөгөөд зөрүү 9 хувийн хүүг Засгийн Газраас хариуцан төлнө. Хөнгөлөлтийн нөхцөлийг (5)-өөс харна уу.

(7) Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан зээл
Худалдаа Хөгжлийн Банктай 2025 оны 4 дугаар сарын 7-ны өдөр Монос Групп болон түүний хамааралтай компаниуд нийт 50 тэрбум төгрөг хүртэл зээлийн эрх бүхий "Зээлийн эрх нээх гэрээ"-г 2 жилийн хугацаатай, 14.4 хувийн хүүтэй байгуулсан. Монос Хүнс ХК нь зүүн бүсийн шинэ агуулахын барилгын төслийн санхүүжилтэд ашиглах зорилгоор тус зээлийн шугамаас 14.4 хувийн хүүтэй, 2027 оны 4-р сарын 7-ний өдөр хүртэл хугацаатай, 8,000,000 мянган төгрөг хүртэлх зээлийн эрх нээлгэсэн.

15. Зээл (үргэлжлэл)

15.2 Санхүүгийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийн тохируулга:

	2025	2024
1 сарын 1-ний үлдэгдэл	26,486,448	44,459,980
Мөнгөн гүйлгээ:		
- Хүлээн авсан зээл	24,476,000	18,377,364
- Зээлийн эргэн төлөлт	(29,371,081)	(38,437,284)
- Төлсөн хүү	(2,195,171)	(2,906,826)
Мөнгөн бус гүйлгээ:		
- Хүүгийн зардал	2,077,189	988,874
- Капиталжуулсан хүү	148,064	1,700,827
- Зээлийн хөнгөлөлтийн хорогдуулга	1,678,419	2,303,513
